

1. ОРЧИН ҮЕИЙН ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

МОНГОЛ ЯАГААД ДЭЛХИЙН ИХ БОДЛОГЫН ГАДНА БАЙДАГ ВЭ?

МУИС, ОУХС-ийн захирал,
доктор (Ph.D) Хиад Ж.Бор

Дэлхийн их бодлогыг зангидаж явсан аль тэртээх XIII-XIV зуунаас хойш Монгол орон зургаан зууны турш дэлхий дахины гадна шоовдор лугаа үлдэж хоцорсон гэдэг. Энэ хэр зэрэг үнэн асуудал вэ. Үнэхээр тийм аваас түүнд учир шалтгаан байна уу, үгүй юу?

Нэгэн зүйл. Монголчууд Газрын дундад тэнгис, Төв Европ зэрэг бүс нутгаас явснаас хойш түүхэн хөгжлийн хувь тавилан эргэж, Өрнөд Европ дэлхийн их бодлогын төв болох өөдрөг замаар замнаж эхэлсэн юм. Гэтэл энэхүү шинэ төвийн дорно зүг чиглэсэн бодлого нь Ойрхи Дорнодоор дамжин хэрэгжиж ирсэн уламжлалтай байлаа /Затгалмайтны долоон удаагийн аян дайн ба XX зууны Ойрхи Дорнодын хямралыг санахтун/. Өрнөдийн энэ бодлого нь эртнээс Иран, Иракаас цааш халилгүй замхарч байсан. Өнөөдөр ч гэсэн Дундад Азид орж ирэлгүйгээр Иранаас Өмнөд Ази, Энэтхэг, Хятадын хойгоор дамжин Хятад хүрээд зогсож байна. Нэгэн зүйл, Дорно зүг чиглэсэн Өрнөд Европын бодлогын бас нэг чиглэл нь Дорнод Европоос дамжин хэрэгжиж байсан авч Орос хүрээд замхарч байлаа. Өнөөдөр ч Өрнөдийн энэ бодлогын хүчтэй шинж чанар нь ОХУ хүрээд үндсэндээ зогсож байна.

Нэгэн зүйл. XX зууны II хагаст дэлхийн их бодлого АНУ-д шилжсэн боловч дээр өгүүлсэн нөхцөл байдал онцны өөрчлөгдөөгүй. Ялгаатай тал нь Европ, Баруун Ази руу чиглэсэн бодлогын хойд чиглэл нь Өмнөд ба Дорнод Европоор дамжин Орост замхарч, өмнөд чиглэл нь Ойрхи Дорнод, Иран, Иракаар дамжин Энэтхэг хүрээд, Дорнод Ази өөд чиглэсэн бодлого нь Номхон Далайгаар дамжин бас л Хятад хүрээд хүчтэй шинж чанар нь зогсож байна.

Нэгэн зүйл. Дэлхийн их бодлого хэрэгжин ирсэн энэ уламжлал олон улсын харилцаанд хоёрдугаар зэргийн шинж чанартай Орос, Хятад зэрэг улсууд Монголоор оролдож байх нөхцөл байдлыг бий болгож өгсөн ажээ.

Нэгэн зүйл. Монгол улс дэлхийн их бодлогоос өрнө, хойд талаасаа Орос орноор, дорно, өмнө талаасаа Хятад улсаар хаалттай нөхцөлд тэрхүү их бодлогод орж очих асуудал зөвхөн бидний өвөрмөц сэдэл, идэвхитэй үйл ажиллагаанаас хамаарна. Тэгэхээр энэ хөөрхийлөлтэй гэмээр нөхцөлд бидний дэвшүүлээд байгаа "олон тулгуурт бодлого", "хоёр хөршийнхөө дунд төвийг сахих бодлого" маань зөв үү? Бидний өмнө босож ирээд буй аварга зорилтод хүрэхэд энэ маань зөв зүйтэй хэрэгсэл болж чадах уу? Үүнийг доод гарчигт хөндөн тэрлэхийг оролдоё.

"Олон тулгуурт бодлого" ба "хоёр хөршийнхөө дунд төвийг сахих бодлого"

Монголчууд XX зууны эхээр тусгаар тогтнолоо олж авснаасаа хойш гадаад бодлогын raison d'etat зарчим буюу хүчний тэнцвэр хадгалах зарчмын хүрээнд хамрагдан орохыг хүсч байсан боловч харамсалтай нь геарройц буюу их гүрний ааглах бодлогын төмөр бахинд хав хавчигдсан билээ.

Гэвч 90-ээд онд Дорнод Европ, Азид ардчиллын гэгээн үзэл санаа нэвтэрч ирснээр Монголчууд геополитикийнхоо таалгүй байдлыг зөөглөх зорилгоор "олон тулгуурт бодлого" баримтлан явуулахаа зарласан билээ. Байрлаас харахад энэ нь стратегийн зорилт мэт харагддаг. Гэвч стратеги номлол ба итгэл үнэмшил хоёрын хоорондын нууц зөрчлийг хэрхэн гаргах, эс бөгөөс геополитикийн бодит нөхцөл байдлыг тооцож хэлж өгсөнгүй. Хоёрын хооронд хэрхэн сонголт хийхийг тооцож хэлж өгсөнгүй. Өөрөөр хэлбэл raison d'etat-ын хувьд харьцангуй шинэлэг зүйл биш боловч геарройц-ийн хувьд шинэлэг зүйлийг Монголчуудын өмнө босгож ирэхдээ тэр бодлого бидний боломжид тохирох эсэх, Монгол орны геополитикийн нөхцөл байдалтай зөрчилдөх эсэхийг бидэнд сайтар ойлгуулж өгсөнгүй.

Тэгэхлээр "олон тулгуурт бодлого" гэдэг маань геарройц-ийн

хувьд шинэлэг зүйл учраас энэ бодлогыг мөрдөхөө тунхагла зарласнаас хойш Монголчууд бид нэг их гүрний бодлогыг зуун хувь аялдан дагалдахаа больсон ажээ. Харин "олон тулгуурт бодлого нь *raison d'état*-ын хувьд харьцангуй шинэлэг зүйл буюу тухайлбал Монголын хувьд геополитикийн таагүй нөхцлийг арилгаж, гадаа орчны хүчний харьцааг тэнцвэржүүлэх гэсэн зорилгоороо шинэ зүйл биш гэлтэй. Өөрөөр хэлбэл 1911 онд мөндөлсөн "туравдаг хүчний бодлого"-той энэ талаараа утга төстэй юм.

Манай геополитикийн орчинд XVII зууны ба XX зууны геополитикийн орчинтой нь харьцуулбал тодорхой өөрчлөлт орж шинэ шинэ хүчин зүйлүүд бий болж буйг үгүйсгэх аргагүй. Өөрөөр хэлбэл манай геополитикийн нөхцөл байдлын буруутан болсоо хоёр хөрш маань нэгд, ардчилгагдаж байна, хоёрт, глобалчиглагдах үйл явцад хүчтэй татагдан орох шинжтэй байна. Манай геополитикийн орчинд орж ирсэн орчин цагийн олон улсыг харилцааны эдгээр шинэлэг хүчин зүйл нь Монголын хувьд сайн муу аль ч талтай байж болно. Тухайлбал хоёр хөрш маань ардчилгадаг нь тэдний гадаад бодлогыг /Монголын талаар бодлогыг/ зөөлрүүлж, уян хатан шинж чанартай болгох боловч геополитикийн даралт, дарамтыг санасан шиг багастахгүй. Гэтэл глобалчлал бидэнд хүсэн мөрөөдөж байснаас маань огт өөр үг дагаар авчирч чадах билээ. Бид Хятадаар дамжиж глобалчиглагдах юм бол эдийн засаг маань энэ салбарт нэг эрчимтэй хүчирхэгжиж байгаа Хятадын бүрэн хараат байдалд орох өндөр магадлалтай. Хэрвээ Оросоор дамжин глобалчиглагдах юм бол эдийн засаг маань хэт улс төржих юм уу, мафичлагдах магадлал илүү ихтэй. Нөгөө талаар ОХУ эдийн засгийн хувьд сэргэж ирмэгцээ хөрш зэргэлдээ улсуудаа дарамталдаг бодлогоос сэргээх нь илэрхий. Үүнийг Путины айлчлал Монголын хувьд нотолж өглөө гэхэд хилсдэхгүй.

Оросын бодлого манай хувьд ямагт хоёрдмол шинжтэй. Хятадын бодлого Монголыг нэгтгэн авах хатуу чиг шугамтай байсныг бид мартаж ёстой. Тиймээс Орос, Хятад хоёрын бодлогын үгийг сайтар шинжиж үзвэл тэдгээр бодлогод чанарын гүн гүнзгий өөрчлөлт гарах яагаа ч үгүй байна гэж хэлж болохоор юм. Энэ бол Орос, Хятадын харилцаанд *raison d'état* зарчим нэвтрэхэд ахиц гараагүйг харуулж буй шинж чанар бөгөөд энэ учир *geopolitics*-ийн

зарчимтай тэдгээр улстай харилцах харилцаандаа төвийг сахих бодлого баримтлахад нэн төвөгтэй болохыг илэрхий болгож байна. Энэ маань ч олон тулгуурт бодлого ба хоёр хөршийнхөө дунд төвийг сахих бодлогын аль алиныг нь явуулж болохгүйг бараг нотлоод өгч байна. Өөрөөр хэлбэл энэ хоёр бодлогын эхнийх нь Монголын хувьд өөрөг сөөрөг урсмал шинж чанартай буюу бараг анархи шинжтэй, нөгөөх нь бодит бодлогоос антид хэт идеалист шинж чанартай байна.

Бид хэрхэх ёстой вэ?

Улс орны удирдагч дөтлөн ирж буй аюулыг урьдчилан мэдэх аваас суурь шинж чанартай гүн гүнзгий шийдвэр гаргах оролдлогыг заавал ч үгүй хийх ёстой. Хэрвээ тэрхүү аюул занал цаг хугацааны улиралтаар улам бүр ихсэх хандлагатай байвал түүнийг үүр уурхайд нь дарж авах ёстой. Хэрэв эд дөтлөж ахуй аюул зөвхөн тухайн цагийн тааламжгүй нөхцлийн үр хөврөл ахуй тэрбээр аюулыг зайлуулах таатай нөхцөл бүрэлдэнэ хэмээх итгэлээр тэр цагийг хүлээх нь зүйтэй. Жишээлбэл хоёр зуун жилийн өмнө Францын ерөнхий сайд алсан Ришелье хамба улс орондоо учирч буй аюул заналыг Франц улсыг хүрээлсэн дайсагнасан хүрээллийг арга зам эрж хайх явдал гэж үзэж байв. Гэхдээ тэрбээр тухайн үедээ тэрхүү нуугдмал аюул чухам юунаас бүрдэж байсныг маш сайн мэдэж байлаа. Тиймээс эхэлсэн үйл явдал юунд хүргэж болохыг Ришелье урьдчилан таах чадсан юм. Ийнхүү тэрбээр бүх нөхцөл байдал бүрэн илэрч ирэхийг хүлээж "цаг хугацаа"-г холбоотноо болгожээ.

Гэтэл манай улсын төрийн болоод дипломатын шинж чанартай үйл ажиллагаа буюу хоёр хөрштэйгээ хамтарч ажиллахаар урьдаас төлөвлөсөн хийсвэр төлөвлөгөө Японыг өөрөөсөө хөндийрүүлж хүйтрүүлэх ойлгомжгүй бодлого, АНУ болон Европын холбооны улсуудад эргэлзээ төрүүлэх байдал зэрэг нь нэгдэн нийлсэн нь Монголын хувьд удаан тэсэж тогтохын аргагүй нөхцөл байдлыг өдгөө бий болгож магадгүй болчихоод байна. Ийм байдлаа гүнзгийрэх аваас манай гадаад бодлогын амин сүнс

алдагдах төдийгүй олон улсын харилцааны явцад хийсвэрлүүлгатай, мөн нэгдмэл ба залгамж шинж чанар төгс болгох нь өөрсдийнхөө задлан шинжилгээнд тулгуурлан үйл ажиллагаа явуулж чадахаа байхад хүрнэ. Үүнийг тойрч гарах арга чарга бидэнд бий юу?

Тэгэхлээр Монголчууд бид хоёр зүйлийг нарийвчлан сэтгэж ялгаж салган тус тусад нь гүн гүнзгий ойлгох ёстой. Өөрөөр хэлбэл хүмүүсийн бүлэг байдгийг бүү умарт. Төрийн тусгаар тогтнолыг өөр өөдөө дэлхийн анхаарлыг татах гэж оролдох нь бидэнд хамгаалах Монголын гадаад бодлого төрийн эрх авсан намын ашигтай юу, аль эсвэл өнөөгийн байдалдаа сэтгэл хангалуун үлдэх бодлогын харгайгаар баруун зүүн тийш холбирахгүйн учир энэ нь ашигтай юу гэдгийг нарийн тунгаах явдал тустай байх нь дамжиггүй буй за. Энэ хоёр замын алиндыг сонгосноос хэрхэх вэ гэдэг хоёр тусдаа аргачлал гарч ирнэ. Хэрвээ бид эхний замыг сонговол дорх хүчин зүйлүүдийг тооцон аргачлалаа боловсруулан гаргах ёстой.

Нэгэн зүйл. Дэлхий дахин эс анхаарч ахуйд тэдний анхаарлыг татахын тулд манайх шиг хоёрхон хөрштэй улс гуравдахь хүчийг ямар нэгэн байдлаар заавал ч үгүй оруулж ирэх шаардлагатай. Энэ нь хоёр хөршийнхөө бодлогыг зөөллөж ухаажуулах, анхаарлыг нь зөв чигтэй болгоход тустай төдийгүй дөрөвдөгч өөр бусад орнуудын бодлого орж ирж байх байнгын сувгийг нээлттэй болгож өгнө.

Нэгэн зүйл. Дэлхийн тэргүүн орны анхаарлыг өөр өөдөө байнга татаж байх үүднээс түүний эрх ашгийг бий болгох оролдлогыг байнга бөгөөд цуцалтгүй хэрэгжүүлэх шаардлагатай тулгарна.

Нэгэн зүйл. Дэлхий нийтийн амин чухал болон олон улсын харилцааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд өндөр идэвхи чанга сонсоглонтой дуу хоолойтой байхыг хичээн оролдох явдал чухал юм.

Эцэст нь хэрвээ бид хоёрдох замыг сонговол мөн л дорх хүчин зүйлүүдийг тооцон аргачлалаа боловсруулан гаргах ёстой.

Нэгэн зүйл. Улс төрийн болон дипломатын хүн бүхэн Монголынхоо төдийгүй Евразийн дипломатын түүхээ гүн гүнзгий мэддэг байх зайлшгүй шаардлагатай. Түүхээсээ сургамж аваагүй ард түмний мөхөл нь ирдэг гэсэн бичигдээгүй хууль бий учраас Монголын унаж боссон түүхийг мэдэхийн учир энэ буюу. Үүнийг чухам төрийн бодлого болгон зангидваас зохилтой.

Нэгэн зүйл. Монголын дипломат бодлогыг гүн гүнзгий утга

Монголын асуудал дээр амархан зохицолдлогийг санагалзан элдвийн интернационализм /пролетарийн болоод социалист/, космополитизмээс зайлсхийж явах нь Монголчууд бидэнд өтгийтэй. Цөөн Монголыг уусгаж алга болгохгүйн учир энэ буюу.

Нэгэн зүйл. Хоёр хөрш маань ил далд олон зөрчилтэй ч Монголын асуудал дээр амархан зохицолдлогийг санагалзан элдвийн интернационализм /пролетарийн болоод социалист/, космополитизмээс зайлсхийж явах нь Монголчууд бидэнд өтгийтэй. Цөөн Монголыг уусгаж алга болгохгүйн учир энэ буюу.

Нэгэн зүйл. Хүндээ хөнгөнөөсөө өгөхгүйн тулд өнөөгийн Монголчуудын бараг онцлог нь болсон атаач, матаач, хэрүүлч, муштаач зангаа орхицгоож, тусгаар тогтнолоор амьсгалж, амьдарч түүнийхээ төлөө бүхнээ зориулах нь бидэнд нэн тустай. Барын сүүл явснаас багтаны толгой болж эрх чөлөөтэй явахын гайхамшиг энэ буюу.

Нэгэн зүйл: Бүх нийтийн эх оронч халуун үзэл, тусгаар тогтнол, үүх түүхээ юунаас ч дээдлэх сэтгэлгээ, улс төрийн тогтвортой байдлыг баттай хангах ба эдийн засгийн хувьд хүчирхэгжих эрмэлзэлтэй бүрэн хослуулж чадвал тавьсан зорилгодоо бид хүрч чадна.

Монгол түмэн минь бүү омтойр, бүү умарт!